



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2025 оны 09 дүгээр сарын 24
№38 (1383)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

222.	Техникийн зохицуулалт шинэчлэн батлах тухай	Дугаар 69	1875
223.	Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангийн хөрөнгийн удирдлагын бодлого батлах тухай	Дугаар 72	1937



᠒᠘᠑᠘	᠑᠖	᠔᠗᠔
᠒᠘᠑᠙	᠒	᠔᠗᠕

ᠨᠢᠨᠵᠢᠰᠢᠷ

ᠪᠣᠮᠢᠨᠢᠭ ᠰᠡᠪᠡᠷ ᠮᠣ ᠵᠢᠰᠢᠷ ᠮᠣ ᠨᠢᠭᠢᠨ ᠮᠣ ᠵᠢᠰᠢᠰᠢᠷ

ᠵᠢᠨᠨᠢᠭ ᠮᠣ ᠵᠢᠰᠢᠰᠢᠰᠢᠷ ᠮᠣᠨᠢᠭᠢᠰᠢᠷ
ᠣᠨᠵᠢᠰᠢᠷ ᠵᠢᠰᠢᠷ

ᠮᠤᠵᠢᠰᠢᠷ ᠮᠣ ᠵᠢᠰᠢᠷ ᠮᠣ ᠨᠢᠭᠢᠨ ᠮᠣ ᠵᠢᠰᠢᠰᠢᠷ
ᠮᠣ ᠵᠢᠰᠢᠰᠢᠷ ᠮᠣ ᠵᠢᠰᠢᠰᠢᠷ ᠮᠣ ᠵᠢᠰᠢᠰᠢᠷ ᠮᠣ ᠵᠢᠰᠢᠰᠢᠷ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 02 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 69

Улаанбаатар
хот

Техникийн зохицуулалт шинэчлэн батлах тухай

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6.7, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 6.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Сүү бэлтгэл, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Техникийн зохицуулалтын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү техникийн зохицуулалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Техникийн зохицуулалт батлах тухай” Засгийн газрын 2011 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 304 дүгээр тогтоолыг энэ тогтоолын 3-т заасан өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Ж.ЭНХБАЯР

Засгийн газрын 2025 оны 02 дугаар
сарын 05-ны өдрийн 69 дүгээр
тогтоолын хавсралт

СҮҮ БЭЛТГЭЛ, СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДААНД МӨРДӨХ ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Нэг.Ерөнхий зүйл

1.1.Зорилго, хамрах хүрээ

1.1.1.Энэхүү техникийн зохицуулалтын зорилго нь малын гаралтай сүү бэлтгэн нийлүүлэх, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, худалдаалах, бүтээгдэхүүнийг буцаах болон татан авах, устгах, дахин боловсруулах, импортлоход тавих шаардлагыг тогтоож, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад оршино.

1.1.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт нийтийн хэрэгцээнд зориулан малын гаралтай түүхий сүү бэлтгэн нийлүүлэх малчин, фермер болон сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, худалдаалах, экспортлох, импортлох эрх бүхий хуулийн этгээд энэ техникийн зохицуулалтыг дагаж мөрдөнө.

1.1.3.Хувийн хэрэгцээнд зориулж сүү бэлтгэх, цагаан идээ боловсруулах, үйлдвэрлэх үйл ажиллагаанд энэ техникийн зохицуулалт хамаарахгүй.

1.2.Норматив эшлэл

-MNS 6737, Хөдөө аж ахуйн зохистой дадал (ХААЗД) хэрэгжүүлэх удирдамж

-MNS 6891, Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлага

-MNS 6406, Мал, амьтны хүүр, сэг зэмийг устгах, халдваргүйжүүлэхэд тавих ерөнхий шаардлага

-MNS 4228, Малын түүхий сүү. Техникийн шаардлага

-MNS 6767, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь гэрэлтүүлгийн хэмжилт, зөвшөөрөх хэмжээнд тавих ерөнхий шаардлага



-MNS 0900, Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Ундны ус. Аюулгүй байдал. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ

-MNS ISO 22000, Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид тавих шаардлага

-MNS CAC RCP 1, Хүнсний эрүүл ахуйн зарчим

-MNS CAC RCP 57, Сүү, сүүн бүтээгдэхүүний эрүүл ахуйн дадлын дүрэм

-MNS 5078, Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага

-MNS 0219, Ундны сүү. Техникийн ерөнхий шаардлага

-MNS 0226, Зайрмаг. Техникийн ерөнхий шаардлага

-MNS 2842, Хатаамал сүү. Техникийн шаардлага

-MNS 4229, Эсэг цагаан идээ. Техникийн шаардлага

-MNS 4230, Уураглаг цагаан идээ. Техникийн ерөнхий шаардлага

-MNS 4528, Тослог цагаан идээ. Техникийн шаардлага

-MNS 6652, Цөцгийн тос. Техникийн шаардлага

-MNS 6858, Хатаамал сүү, сүүн бүтээгдэхүүн. Техникийн ерөнхий шаардлага

-MNS GOST R 51331, Йогурт. Ерөнхий шаардлага

-MNS CAC 193, Хүнсний бүтээгдэхүүн дэх хорт болон бохирдуулагч бодисын ерөнхий стандарт

-MNS CAC MRL 2, Мал, амьтны гаралтай хүнсэн дэх эм, бэлдмэлийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ, эрсдэлийн менежментийн зөвлөмж

-MNS 6308, Хүнсний бүтээгдэхүүн дэх бичил биетний аюулгүй байдал болон эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээ

-MNS 5867, Хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах меламины зөвшөөрөгдөх дээд хэмжээ

-MNS 4504, Хүнсний бүтээгдэхүүн дэх хүнд металлын зөвшөөрөгдөх дээд хэмжээ

-MNS 5868, Хүнсний бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ

-MNS 6361, Хүнс, малын тэжээл дэх микотоксины үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ

-MNS CAC 192, Хүнсний нэмэлт

-MNS 5684, Сав, баглаа, боодлын материалд агуулагдах, хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ

-MNS 6648, Хүнсний бүтээгдэхүүний сав, боодлын шошгололтод тавих шаардлага

-MNS 5343, Хүнсний түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага

-MNS 6561, Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага

-MNS ISO/IEC 17025, Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага

-MNS 5344, Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага

-“Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах журам”

-“Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрт эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал”-ыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар

1.3.Энэхүү техникийн зохицуулалтад ашигласан дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:



1.3.1. “Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр” гэж эрх бүхий байгууллагын бүртгэл, дүгнэлттэй, сүү хүлээн авах, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах, савлах, нийтийн хэрэгцээнд нийлүүлэх үйл ажиллагаа эрхлэхэд зориулсан орчин, талбай бүхий, хоногт 1 тонноос дээш хэмжээний сүүг хүлээн авч боловсруулах хүчин чадал бүхий байгууламжийг;

1.3.2. “Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах цех” гэж эрх бүхий байгууллагын бүртгэл, дүгнэлттэй, сүү хүлээн авах, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах, савлах, нийтийн хэрэгцээнд нийлүүлэх үйл ажиллагаа эрхлэхэд зориулсан орчин, талбай бүхий, хоногт 1 тонн болон түүнээс доош хэмжээний сүүг хүлээн авч боловсруулах хүчин чадал бүхий байгууламжийг;

1.3.3. Түүхий эд, бүтээгдэхүүнд хамаарах нэр томьёо, тодорхойлолт:

4.1.1-д заасныг;
-“Мал” гэж Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн

“Сүүний анхан шатны үйлдвэрлэл эрхлэгч” гэж малын түүхий сүүг бэлтгэн нийлүүлж буй малчин, фермер эрхлэгчийг;

-“Малчин” гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасныг;

-“Фермер” гэж мал, тэжээвэр амьтныг хагас болон бүрэн эрчимжсэн аргаар, тавлаг байдлыг хангасан байранд маллаж, нэмэлт тэжээлээр тэжээж, ашиг шимээр нь үндсэн орлогоо олдог иргэн, хуулийн этгээдийг;

-“Пестицидийн үлдэгдэл” гэж Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 4.1.10-д заасныг;

-“Мал, амьтны эмийн үлдэц” гэж Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 4.1.11-д заасныг;

-“Саалийн мал” гэж сааж сүүг нь ашигладаг эх малыг.

1.3.4. “Сүү” гэж малын дэлэнгийн булчирхайн шүүрлийн үр дүнд бий болсон, ямар нэгэн бодис, нэгдэл нэмээгүй, эсхүл сүүний бүрэлдэхүүн хэсгээс ялгаагүй биологийн шингэнийг:

-“түүхий сүү” гэж малаас сааж, зөвхөн анхан шатны боловсруулалт (шүүх, хөргөх) хийсэн сүүг;

-“бүтэн сүү” гэж сүүний бүрэлдэхүүнд (тос, уураг, хуурай бодис гэх мэт) ямар нэгэн тохируулга хийгээгүй сүүг;

-“тосгүй сүү” гэж 0.5 хувиас бага тостой сүүг;

-“ундны сүү” гэж сүүний бүрэлдэхүүн хэсгийн харьцааг тохируулж, дулааны аргаар боловсруулсан шууд ууж хэрэглэх зориулалттай сүүг;

-“сүүний бүрэлдэхүүн хэсэг” гэж хуурай бодис (сүүний тос, уураг, нүүрс ус, лактоз, фермент, аминдэм, эрдэс бодис) усыг.

1.3.5.“Уламжлалт цагаан идээ” гэж уламжлалт аргаар бэлтгэсэн сүүн бүтээгдэхүүнийг;

1.3.6.“Баяжуулсан сүүн бүтээгдэхүүн” гэж аминдэм, эрдэс бодисыг дангаар болон холимог хэлбэрээр үйлдвэрийн аргаар нэмж үйлдвэрлэсэн сүү, сүүн бүтээгдэхүүнийг;

1.3.7.“Зохицуулах үйлчлэлтэй сүүн бүтээгдэхүүн” гэж хүний бие махбодыг бүхэлд нь эсхүл тодорхой эрхтэн системийн үйл ажиллагааг дэмжих биологийн идэвхт нэгдэл, амьд бичил биетэн агуулсан эсхүл хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх бодисын агууламжийг багасгаж найрлагыг тохируулсан, өдөр тутам хэрэглэхэд сөрөг нөлөөгүй, эм, биобэлдмэлийн хэлбэрээр үйлдвэрлэж савлаагүй сүүн бүтээгдэхүүнийг;

1.3.8.“Сүүн бүтээгдэхүүн” гэж малын гаралтай сүүгээр үйлдвэрлэсэн исэг, уурагт, тослог сүүн бүтээгдэхүүн, уламжлалт цагаан идээг;

1.3.9.“Тослог сүүн бүтээгдэхүүн” гэж малын сүүний тосыг ялган бэлтгэсэн бүтээгдэхүүнийг;

-“цөцгий” гэж сүүнээс ялгаж авсан, 10 хувиас багагүй тосны агууламжтай сүүн бүтээгдэхүүнийг;

-“түүхий цөцгий” гэж 45°C-аас дээш температурт дулааны боловсруулалт хийгээгүй цөцгийг;

-“ундны цөцгий” гэж дулааны боловсруулалт хийсэн, шууд хэрэглэх зориулалттай цөцгийг;

-“цөцгийн тос” гэж цөцгийнд агуулагдах тосыг механик үйлчлэлээр бөөгнөрүүлэн ялгаж, сийвэнг жигд тархаасан 75 хувиас багагүй тосны агууламжтай бүтээгдэхүүнийг;

-“амтлаг цөцгийн тос” гэж халааж, ариутгасан цөцгийгөөр үйлдвэрлэсэн цөцгийн тосыг;

-“исэг цөцгийн тос” гэж халааж ариутгасан цөцгийг сүүн хүчлийн бичил биетний цэвэр өсгөврийн хөрөнгөөр исгэж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг;

-“зөөхий” гэж цөцгийг сүүн цэвэр өсгөврийн хөрөнгөөр бүрэлдүүлсэн, 20 хувиас багагүй тосны агууламжтай исэг бүтээгдэхүүнийг;

-“пахта” гэж цөцгийн тос үйлдвэрлэхэд дагалдан гарах бүтээгдэхүүнийг;

-“шар тос” гэж цөцгийн тос, цөцгийг өндөр температурт хайлж, уургийн үлдэгдэл, цөвөөс ялгасан 98 хувиас багагүй тосны агууламжтай бүтээгдэхүүнийг.

1.3.10.“Исэг сүүн бүтээгдэхүүн” гэж малын сүүг бичил биетний цэвэр өсгөврийн хөрөнгөөр бүрж, исгэж боловсруулсан сүүн бүтээгдэхүүнийг:

-“тараг” гэж малын сүүг сүүн хүчлийн цэвэр өсгөврийн хөрөнгийг дангаар, эсхүл холимог байдлаар хөрөнгөлж бүрсэн исэг сүүн бүтээгдэхүүнийг;

-“айраг” гэж гүүний сүүг уламжлалт аргаар исгэж боловсруулсан бүтээгдэхүүнийг;

-“йогурт” гэж малын сүүг сүүнхүчлийн цэвэр өсгөврийн хөрөнгийг дангаар, эсхүл холимог байдлаар хөрөнгөлж бүрэлдүүлсэн, сүүний тосгүй хуурай бодис ихтэй исэг сүүн бүтээгдэхүүнийг;

-“хоормог” гэж ингэний сүүг уламжлалт аргаар исгэж боловсруулсан бүтээгдэхүүнийг.

1.3.11.“Уурагт сүүн бүтээгдэхүүн” гэж малын сүүний казеин уураг болон шар сүүний уургийг ялгаж бэлтгэсэн бүтээгдэхүүнийг:

-“аарц” гэж сүүн хүчлийн хөрөнгөөр хөрөнгөлж, улмаар хүчил, хүчил-ферментийн үйлчлэлээр казеиныг тунадасжуулан шар сүүнээс ялган авсан бүтээгдэхүүнийг;

-“аарцмаг” гэж аарцанд цөцгий, цөцгийн тос болон төрөл бүрийн амтлагч бодис нэмж, холих, хутгах, жигдрүүлэх зэрэг механик аргаар боловсруулсан уурагт амтлаг бүтээгдэхүүнийг;



-“аарцанцар” гэж аарцан бүтээгдэхүүн, амталсан аарцыг шоколадан бүрхүүлээр бүрж, хэвлэн хөлдөөсөн бүтээгдэхүүнийг;

-“ааруул, хурууд” гэж тараг, хоормогийг буцалгаж шар сүүг шүүн аарц бэлтгэж, хэвлэн нягтруулж, тусгай хэвээр, эсхүл уламжлалт аргаар хэлбэржүүлэн хатаасан бүтээгдэхүүнийг;

-“сүүн хурууд” гэж түүхий сүүг өөрөөр нь исгэж, тосны агууламжийг нэмэгдүүлэн шар сүүнээс нь ялгаж, нягтруулан хэвлэж хатаасан бүтээгдэхүүнийг;

-“бяслаг” гэж түүхий сүүг бичил биетний цэвэр өсгөврийн хөрөнгө, ферментийн үйлчлэлээр ялган тусгай горимд тунадасжуулж, ээдмийг шар сүүнээс ялган хэвлэж, шахаж, боловсруулсан уурагт бүтээгдэхүүнийг;

-“зөөлөн бяслаг” гэж сүүний уургийг хүчил, хүчил-ферментийн аргаар эздүүлж, ээдмийг шахаж, биологийн боловсруулалт хийх, эсхүл биологийн боловсруулалт хийлгүйгээр үйлдвэрлэсэн 40 хувиас бага чийглэгтэй бүтээгдэхүүнийг;

-“хатуу, хагас хатуу, хэт хатуу бяслаг” гэж бичил биетний үйлчлэл, ферментийн аргаар тунадасжуулан ялгасан ээдмийг дулааны үйлчлэлд оруулж, хэвлэн шахаж, давсны уусмалд сойж, давслах, биологийн боловсруулалт, бойжилтын аргаар үйлдвэрлэсэн, 39 хувиас багагүй чийглэгтэй бүтээгдэхүүнийг;

-“хайлмал бяслаг” гэж зөөлөн буюу хатуу бяслагийг уусгагч давсны тусламжтайгаар дулааны үйлчлэлээр хайлж, төрөл бүрийн амтлагч нэмж амталсан тусгай байдлаар хэлбэржүүлэн хэсэгчлэн савласан 40 хувиас багагүй чийглэгтэй бүтээгдэхүүнийг;

-“монгол бяслаг” гэж сүүний уургийг дулаан, хүчлийн аргаар ялган нягтруулж хэвлэсэн бүтээгдэхүүнийг;

-“казеин” гэж тосгүй сүүнээс гаргаж авсан сүүний үндсэн уургийг;

-“шар сүүний уураг” гэж казеиныг тунадасжуулсны дараа шар сүүнд үлдэх уургийг.

1.3.12.“Хүүхдийн тэжээлийн сүүн бүтээгдэхүүн” гэж найрлагад нь сүүн бус бүрдэл хэсгийг 20 хувиас ихгүй хэмжээгээр нэмсэн хүүхдийн тэжээлийн зориулалттай сүүн бүтээгдэхүүнийг;

–“нялх болон балчир хүүхдийн сүүн тэжээл” гэж гурав хүртэлх насны хүүхдэд зориулсан сүү, сүүн болон тэдгээртэй адилтгах бүтээгдэхүүнийг;

–“сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулсан хүүхдийн сүүн тэжээл” гэж 2-оос 5 хүртэлх насны хүүхдийн хоол хүнсэнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг;

–“сургуулийн насны хүүхдэд зориулсан сүүн тэжээл” гэж 6-аас 14 хүртэлх насны хүүхдийн хоол хүнсэнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг.

1.3.13.“Нөөшилсөн сүүн бүтээгдэхүүн” гэж малын сүү, сүүн бүтээгдэхүүний хадгалалтын хугацааг тохиромжит аргаар уртасгасан бүтээгдэхүүнийг:

–“хатаамал сүү” гэж хуурай бодисын агууламж нь 95 хувиас багагүй болтол сүүний усыг ууршуулсан бүтээгдэхүүнийг;

–“тосгүй хатаамал сүү” гэж хуурай бодисын агууламж нь 95 хувиас багагүй болтол сүүний усыг ууршуулсан, 1.5 хувиас ихгүй тослогийн агууламжтай бүтээгдэхүүнийг;

–“өтгөрүүлсэн сүү” гэж малын сүүнээс усны тодорхой хэсгийг ялгаж өтгөрүүлж нөөшилсөн бүтээгдэхүүнийг;

–“сэргээсэн сүүн бүтээгдэхүүн” гэж өтгөрүүлсэн болон хатаамал сүүг усанд уусган механик болон дулааны боловсруулалт хийж хэвийн сүүний төлөвт шилжүүлж, түүгээр үйлдвэрлэсэн сүүн бүтээгдэхүүнийг;

–“хатаамал аарц” гэж хуурай бодисын агууламж нь 95 хувиас багагүй байхаар усыг ууршуулсан аарцыг;

–“хатаамал тараг” гэж хуурай бодисын агууламж нь 95 хувиас багагүй байхаар усыг ууршуулсан таргийг.

1.3.14.Бусад сүүн бүтээгдэхүүн:

–“шар сүү” гэж бяслаг, аарц, ээдэм, казеин үйлдвэрлэхэд дагалдан гарах бүтээгдэхүүнийг;

–“зайрмаг” гэж сүү болон сүүн бус нэмэлт бодисыг агаараар сийрэгжүүлэн хөлдөөсөн, хөлдүү биет байдалтай чихэрлэг сүүн бүтээгдэхүүнийг;



-“цэцгийтэй зайрмаг (пломбир)” гэж 11.6-20 хувийн тосны агууламжтай зайрмагийг;

-“исэг сүүн зайрмаг” гэж бичил биетний хөрөнгө, эсхүл эсэг бүтээгдэхүүн ашиглан үйлдвэрлэсэн 7.5 хувиас ихгүй тосны агууламжтай зайрмагийг;

-“ургамлын тостой зайрмаг” гэж ургамлын тос, эсхүл сүүний тостой хольцын эзлэх хэмжээ 12 хувиас ихгүй байх зайрмагийг;

-“зөөлөн зайрмаг” гэж -5°C - 7°C -ын температурт зайрмагтуулсан, шууд хэрэглээнд зориулсан зайрмагийг;

-“бэхжүүлсэн зайрмаг” гэж -18°C -аас доошгүй температурт хөлдөөсөн, хадгалах, тээвэрлэх, борлуулахад заасан температурыг хэвээр хадгалах зайрмагийг.

1.13.15.“зайрмагийн шингэн хольц” гэж зайрмагийн үйлдвэрлэлд шаардлагатай түүхий эд, сүүний бүрэлдэхүүн хэсгийг агуулсан шингэн сүүн бүтээгдэхүүнийг;

1.3.16.“зайрмагийн хуурай хольц” гэж зайрмагийн шингэн хольцыг хатаасан хатаамал сүүн бүтээгдэхүүнийг;

1.3.17.“сүүн ундаа” гэж сүү, сүүн бүтээгдэхүүний 10-аас доошгүй хувийн агууламжтай бүтээгдэхүүнийг;

1.3.18.“бичил биетний цэвэр өсгөврийн хөрөнгө” гэж хүнсийг боловсруулах шатанд үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглэдэг бичил биетэн, тэдгээрийн биомасс бэлдмэлийг;

1.3.19.“хувиргасан амьд организм” гэж Хувиргасан амьд организмын тухай хуулийн 3.1.2-т заасныг;

1.3.20.Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи ажилбарт хамаарах нэр томъёо, тодорхойлолт:

-“шүүж цэвэрлэх” гэж сүүний механик бохирдлыг зориулалтын шүүлтүүр, сүү цэвэрлэх сепараторын тусламжтай ялгахыг;

-“тос ялгах” гэж сүү, сүүн бүтээгдэхүүний тосны агууламжийг тохируулах зорилгоор сүүнээс тосыг зориулалтын сепаратораар ялгахыг;



–“тохируулга хийх” гэж сүү, сүүн бүтээгдэхүүний тосны агууламжийг стандартын шаардлагад нийцүүлэн тос, уураг, хуурай бодисын нийт жинд эзлэх хувь хэмжээг ихэсгэх, багасгах зорилгоор бүтээгдэхүүнээс ялгах, нэмэхийг;

–“жигдрүүлэх” гэж сүүний тосны бөмбөлгийг даралт, өндөр давтамж, хэт авиа зэрэг механик үйлчлэлээр бутлан жижиглэхийг;

–“дулаанаар боловсруулах” гэж сүүнд агуулагдах бичил биетний тоог дулааны үйлчлэлээр бууруулах, устгахыг;

–“ариутгах” гэж сүүг 104°C-125°C-ын температурт ариутгах технологи ажилбарыг;

–“хэт өндөр температурт ариутгах” гэж ариутгалыг битүү системд 125°C-140°C-ын температур гадаргуугаар урсгаж ариутгах, эсхүл 135°C-140°C-ын температуртай уураар хоёроос доошгүй секундийн барилттайгаар ариутгах ажилбарыг;

–“исгэх” гэж сүүний бүтэц, бүрэлдэхүүн, шинж чанарыг бичил биетний үйлчлэлээр өөрчлөх зорилгоор тухайлсан горим, хугацаанд боловсруулахыг;

–“ээдүүлэх” гэж уурагт сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд сүүн дэх уургийг задлахыг;

–“тос цохих” гэж цөцгийг механик үйлчлэлээр боловсруулахыг;

–“шар сүү ялгах” гэж уурагт сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд жингийн нөлөөгөөр шар сүүг ялгахыг;

–“хайлах” гэж дулааны үйлчлэлээр хатуу төлөвтэй сүүн бүтээгдэхүүнийг шингэн, зөөлөн хэлбэрт оруулахыг;

–“утах” гэж бяслагийг давирхайгүй хуурай модны утаагаар тусгай камерт утаж, боловсруулахыг;

–“сүү, сүүн бүтээгдэхүүнийг баяжуулах” гэж эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн, Монгол Улсад бүртгэлтэй баяжуулагч бэлдмэлийг стандартад заасан нөхцөл, технологийн дагуу үйлдвэрийн аргаар сүү, сүүн бүтээгдэхүүнд нэмэхийг;

–“хөргөх” гэж бичил биетний үржлийг хязгаарлах, бүтээгдэхүүнийг биежүүлэхээр нам температурт барилт хийхийг;

-“зайрмагтуулах” гэж зайрмагийн хольцыг агаараар сийрэгжүүлэн зайрмагтуулан хөлдөөхийг;

-“өтгөрүүлэх” гэж сүүний усны агууламжийг багасгаж, хуурай бодисыг нэмэгдүүлэхийг;

-“хатаах” гэж сүү, сүүн бүтээгдэхүүний чийгийг тодорхой хэмжээнд хүртэл бууруулахыг;

-“хөлдөөж хатаах (сублимаци)” гэж сүүний усыг шингэн төлөвөөс хатуу төлөвт шилжүүлэн, хатуу төлөвөөс хийн төлөвт шилжүүлэн хуурай бодисын агууламжийг нэмэгдүүлэхийг;

-“сэргээх” гэж өтгөрүүлсэн болон хатаамал сүүг усанд уусган механик, дулааны аргаар боловсруулж хэвийн сүүний төлөвт шилжүүлэхийг;

-“устгах” гэж хүний амь нас, эрүүл мэндэд аюултай болох нь тогтоогдсон, эсхүл гарал үүсэл нь тодорхойгүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүн, мал, амьтны хэрэглээнээс хасахыг”.

1.3.21.“чөлөөт бүс” гэж Чөлөөт бүсийн тухай хуулийн 3.1.1-д заасныг.

Хоёр.Сүүний анхан шатны үйлдвэрлэл эрхлэгчид болон түүхий сүү бэлтгэхэд тавигдах шаардлага

2.1.Нийтийн хэрэгцээнд зориулан түүхий сүү бэлтгэн нийлүүлэх малчин дараах шаардлагыг хангана:

2.1.1.Саальчин саалийн хугацаанд эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд бүрэн хамрагдсан байх;

2.1.2.Саалийн малыг саахдаа гарыг тогтмол, зөв угааж хэвших, саалийн явцад хувийн ариун цэврийг сайтар сахиж, нийтийн хэрэгцээнд нийлүүлэх сүүг бохирдуулахгүй байх;

2.1.3.Малын хашаа, хороо, саравчнаас бууц, малын ялгадсыг тогтмол цэвэрлэж, зайлуулдаг байх;

2.1.4.Саалийн малыг задгай бэлчээрээр малладаг бол гэр, сууцнаас зайтай, цэвэр орчинд саалийн зэлийг байршуулж, бороо, хур орох, шавхайтах бүрд зөөж, сэлгэдэг байх;



2.1.5. Мал сүрэгт халдварт, гоц халдварт өвчний шинж тэмдэг ажиглагдсан тохиолдолд малын эмчид нэн даруй мэдэгдэж, шинжилгээнд хамруулах, шинжилгээний хариу гарах хүртэл сүүг нийтийн хэрэгцээнд нийлүүлэхгүй байх;

2.1.6. Ахуйн хог, хаягдал, малын өтөг бууц, ялгадас цуглуулах цэг, бие засах газрыг малын хашаа, хороо, саалийн зэл байрлах газраас зайдуу, ноёлох салхины доор байршуулж, тодорхой хугацаанд устгаж, зайлуулдаг байх;

2.1.7. Сүүг түр хадгалах тохиолдолд мал, амьтдаас тусгаарлан, хөргөж хадгалах;

2.1.8. Саалийн малыг саах болон сүүг түр хугацаанд хадгалж агуулах, зөөвөрлөхдөө эрүүл ахуйн шаардлага хангасан, хуванцар бус сав, суулга хэрэгслийг ашигладаг байх;

2.1.9. Зориулалтын бус хуванцар саванд агуулсан сүү, сүүн бүтээгдэхүүнийг хүнсний болон нийтийн хэрэгцээнд зориулан ашиглахгүй байх.

2.2. Нийтийн хэрэгцээнд зориулан түүхий сүү бэлтгэн нийлүүлэх фермер нь дараах шаардлагыг хангасан байна:

2.2.1. Түүхий сүү бэлтгэн, нийтийн хэрэгцээнд нийлүүлэх фермер нь “MNS 6737, Хөдөө аж ахуйн зохистой дадал (ХААЗД) хэрэгжүүлэх удирдамж”, “MNS 6891, Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлага” стандартыг хангасан байх;

2.2.2. “Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрт эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал”-ыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар”-ын холбогдох шаардлагыг хэрэгжүүлж ажилладаг байх;

2.2.3. Хүрээлэн буй орчныг бохирдуулах болон орчны бохирдлоос үүсэлтэй малын өвчлөл бий болох, сүүний чанар муудах эрсдэлээс сэргийлсэн арга хэмжээг хэрэгжүүлдэг байх;

2.2.4. Сүү саах, хөргөх, хадгалах байр нь цэвэрлэгээ хийхэд тохиромжтой, агааржуулалт, нарны гэрлийн тусгалыг бүрэн шийдсэн, бохир хуримтлагдахгүй байх нөхцөлийг бүрдүүлж, зайлуулах суваг хийсэн байх, сүү бохирдуулах эрсдэлээс сэргийлсэн байх;

2.2.5. Малын халдварт болон гоц халдварт өвчний сэжиг бүхий малыг сүргээс тусгаарлах боломжийг бүрдүүлсэн байх;



2.2.6.“MNS 5344, Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага” стандартыг мөрдөж ажиллах;

2.2.7.Хог хаягдлын цэг ба ариун цэврийн цэг (бие засах газар)-ийг малын хашаа, саравч, хороо, фермийн байрнаас зайтай, ноёлох салхины дор байршуулах;

2.2.8.Эм, эмийн бодис малын биеэс гадагшлах хугацаа дуусаагүй малыг саальд хамруулахгүй байх;

2.2.9.Саалийн малыг шилжүүлэх, тээвэрлэх, зөөвөрлөх тохиолдолд халдвар дамжин тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор мал эмнэлгийн тасагт урьдчилан мэдэгдэж, тухайн малд үзлэг хийлгэж, бүртгүүлэх, шаардлагатай тохиолдолд малаас сорьц, дээж авч мал эмнэлгийн байгууллагад хүргүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх;

2.2.10.Фермийн байранд өвчний голомт, халдвар бүхий газраас хүн, тээврийн хэрэгсэл нэвтрэх, халдвар дамжих эрсдэлээс сэргийлж, эрх бүхий байгууллагаас баталсан биохамгааллын зааврыг мөрдөх;

2.2.11.Харьяа нутаг дэвсгэрийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжтэй гэрээ байгуулж саалийн малыг малын эмчийн байнгын хяналтад байлгах;

2.2.12.Урьдчилан сэргийлэх тарилга, туулгалтыг мал эмнэлгийн байгууллага, малын эмчийн зөвлөсөн хугацаанд хийлгэж, малын эрүүл мэндийн дэвтрийг тогтмол хөтлөх;

2.2.13.Сүүгээр дамжин халдварлах өвчний шинж тэмдэггүй, сүүний чанарт нөлөөлөхүйц шархгүй, эрүүл малын сүүг нийтийн хэрэгцээнд нийлүүлдэг байх.

2.3.Үйлдвэр, цехэд нийлүүлэх түүхий сүүнд тавигдах шаардлага

2.3.1.Хүнсний сүлжээнд нийлүүлэх түүхий сүү нь “MNS 4228, Малын түүхий сүү, Техникийн шаардлага” стандартад заасан мэдрэхүйн эрхтэн, физик, хими, эрүүл ахуй, аюулгүй байдлын үзүүлэлтийн шаардлагыг хангасан байх;

2.3.2.Хүүхдийн сүүн тэжээлийн үйлдвэр, цехэд нийлүүлэх түүхий сүү нь “MNS 4228, Малын түүхий сүү, Техникийн шаардлага” стандартад заасан дээд зэргийн сүүний шаардлагыг хангасан байх;



2.3.3. Дэлэнгийн үрэвсэл, сүрьеэ, бруцеллөз зэрэг малаас хүнд дамжин халдварлах халдварт болон гоц халдварт өвчнөөс ангид эрүүл, тайван бүсээс бэлтгэсэн, гарал үүсэл нь баталгаажсан байх.

Гурав. Үйлдвэр, цехийн барилга, байгууламж, дотоод хяналтын лабораторид тавигдах шаардлага

3.1. Сүү, сүүн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэр, цехийн барилга, байгууламж, дэд бүтэц дараах шаардлагыг хангасан байна:

3.1.1. Үйлдвэр, цехийн барилга, байгууламж нь мэргэжлийн байгууллагын зураг төсвийн дагуу барьж, улсын бүртгэлд бүртгүүлсэн, норматив эшлэлд заасан холбогдох стандарт, баримт бичигт тусгасан шаардлагыг хангасан байх;

3.1.2. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр, цех (цаашид “үйлдвэр”, “цех” гэх) нь аливаа тохиромжгүй орчин (үерийн аюул, ус, намаг, цэвдэг, сул шороо, хог хаях цэг, эвгүй үнэр, утаа, тоос, бусад бохирдол)-оос тусгаарлагдсан, салхины чиглэлийн дээд талд цэвэр орчинд байрлах;

3.1.3. Сүү, сүүн бүтээгдэхүүн хүлээн авах, боловсруулах, үйлдвэрлэх, савлах, хадгалах, тээвэрлэлтэд шилжүүлэх зэрэг үйлдвэрлэлийн технологийн шат, дамжлагыг оновчтой зохион байгуулсан байх;

3.1.4. Үйлдвэр, цехийн барилга байгууламжийн байршлыг тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг нь өөрчлөхөд эрх бүхий байгууллагаас дүгнэлт гаргуулсан байх;

3.1.5. Сүү, сүүн бүтээгдэхүүний тээврийн хэрэгслийг угаах, халдваргүйтгэл хийх талбай, угаалгын газартай байх, эсхүл хүнсний бүтээгдэхүүнийг тээвэрлэх зөвшөөрөл бүхий байгууллагатай гэрээ байгуулж ажилладаг байх;

3.1.6. Сүү хүлээн авах өрөө нь боловсруулах өрөөнөөс тусгаарлагдсан байх;

3.1.7. Ажилчдын хувцас солих болон ариун цэврийн өрөөний хаалга нь үйлдвэрлэлийн байрны хэсэгт шууд онгойхгүй байхаар зохион байгуулсан байх;

3.1.8. Сав баглаа боодол, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, цэвэрлэгээ, ариутгалын бодисыг хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээс тусад нь төрөлжүүлэн хадгалах өрөө тасалгаатай байх;



3.1.9. Усан хангамж, ариутгах татуургын төвлөрсөн, эсхүл хэсгийн шугам сүлжээнд холбогдсон, угаалга, цэвэрлэгээ хийх боломжтой, халуун усаар хангагдсан байх;

3.1.10. Хүүхдийн тэжээлийн сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг ариун цэвэр, эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан, 80°C-аас доошгүй температуртай халуун ус бүхий усан хангамжтай, техникийн ус зайлуулах сувагтай, түүнийг тусгай өнгөөр будаж ялгасан байх;

3.1.11. Усыг дахин ашиглах системтэй бол холбогдох стандартад заасан шаардлагын дагуу цэвэршүүлэх ба дахин ашиглах усны түгээх хоолой нь өнгөөр ялгасан, тусдаа шугамтай байх;

3.1.12. “MNS 6767, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь гэрэлтүүлгийн хэмжилт, зөвшөөрөх хэмжээнд тавих ерөнхий шаардлага” стандартыг хангасан гэрэлтүүлэгтэй байх;

3.1.13. “MNS 5078, Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага” стандартын шаардлагыг хангасан агааржуулалт, салхивчтай байх;

3.1.14. Үйлдвэр, цехийн халуун боловсруулалтын хэсэгт конденсаци үүсээгүй байх;

3.1.15. Хөргөлтийн систем, түүнд ашиглаж буй хөргөлтийн бодис нь озон задалдаг болон бусад орлуулах бодис агуулсан бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөлтэй байх;

3.1.16. Сүү, сүүн бүтээгдэхүүнийг хадгалах хөргөгч, хөлдөөгч болон хөргүүртэй агуулахыг тогтмол цэвэрлэдэг, агаар сэлгэлтийг тогтмол хийдэг, температур, чийгшил, хадгалах горимыг тогтмол хянаж, бүртгэдэг байх;

3.1.17. Хөргөлтийн систем нь конденсац (ууршилтаас үүссэн талст болон шингэн)-ыг цуглуулах, зайлуулах боломжтой байх;

3.1.18. Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, цехийн барилга, байгууламж нь цахилгаан, дулааны төвлөрсөн болон хэсгийн сүлжээнд холбогдсон байх;

3.1.19. Цахилгаан хангамж тасалдсан тохиолдолд болзошгүй эрсдэлээс сэргийлж, өөрийн нөөц цахилгааны үүсгүүртэй байх;



3.1.20.Хэсгийн халаалтыг цахилгаан болон бусад эх үүсвэрээр шийдэж, галлагаатай тохиолдолд галлагааны хэсгийг тусад нь төлөвлөж, барьсан байх;

3.1.21.Халаалтын зуух ашиглах тохиолдолд батлагдсан зураг, төсвийн дагуу мэргэжлийн байгууллагаар барилга угсралтыг гүйцэтгүүлж, хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бүртгүүлэн ашиглах зөвшөөрөл авсан байх;

3.1.22.Үйлдвэр, цехээс ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх хаягдал усны бохирдуулагч бодисын хэмжээ нь “MNS 6561, Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага” стандартын шаардлагыг хангасан байх;

3.1.23.Ус зайлуулах шугам нь цэвэр бүсээс бохир бүс рүү гарах чиглэлтэй байх, шингэн хаягдал бохир усны цооног, худаг нь үйлдвэрийн түүхий эд, эцсийн бүтээгдэхүүн орох, гарах хэсэгт байрлаагүй байх;

3.1.24.Үйлдвэрийн болон хатуу хог, хаягдлыг түр цуглуулах цэгийг зориулалтын сав, хашаагаар тусгаарласан, үйлдвэрийн бохир хэсгийн чиглэлд байрласан байх;

3.1.25.Хатуу хаягдлыг зайлуулах ажиллагааг хүрээлэн буй орчинд бохирдол үүсгэхгүй байхаар төлөвлөж, гадна хогийн савыг галд тэсвэртэй материалаар хийх, хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлуулах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн байх;

3.1.26.Хог хаягдлыг цуглуулах зориулалтын цэг, хогийн цооногийг усны эх үүсвэрээс 200 метр, үйлдвэрийн барилга, байгууламжаас 30 метрээс багагүй зайд, ноёлох салхины доод талд байрлуулж, зориулалтын хаалт, хашаагаар тусгаарлан, тогтмол зайлуулж халдваргүйжүүлдэг байх.

3.2.Үйлдвэр, цехийн дотоод хяналтын лабораторид тавих шаардлага:

3.2.1.Үйлдвэр, цех нь дотоодын чанарын хяналтын лабораторитой байх, эсхүл итгэмжлэгдсэн лабораторитой гэрээ байгуулан дотоод хяналтыг хэрэгжүүлэх;

3.2.2.Түүхий эд нийлүүлэгчийн шинжилгээний бичиг нь олон улсын стандартад нийцэж байгааг баталгаажуулсан тохиолдолд тухайн баримт бичгийг хүчин төгөлдөр гэж үзэх;



3.2.3.Дотоод хяналтын лабораторид хэрэглэх урвалж бодис нь хадгалалтын хугацаа дуусаагүй байх, зохих нөхцөл шаардлага, горимыг баримтлан хадгалах.

Дөрөв.Үйлдвэр, цехийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд тавигдах шаардлага

4.1.Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд технологи, эрүүл ахуйн шаардлага хангасан, угааж цэвэрлэж, халдваргүйжүүлэхэд хялбар хийцтэй, хүнсний зориулалтын материалаар хийгдсэн, хүнстэй харьцах гадаргуу нь тэгш гөлгөр (нүх, сүв, ан цавгүй) шугам хоолой, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл ашиглах;

4.2.Үйлдвэрлэлийн хэмжих хэрэгслийг эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан байх;

4.3.Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтын тоног төхөөрөмж, зөөврийн хэрэгсэл нь тусгайлсан таних тэмдэгтэй байх;

4.4.Технологийн дамжлага дунд хэрэглэх сав, суулга, хэрэгсэл нь хүнсний зориулалтын материалаар хийгдсэн байх;

4.5.Тоног төхөөрөмж, сав, багаж хэрэгслийг цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэл хийхэд тохиромжтой байхаар суурилуулж, байрлуулсан байх;

4.6.Хүнсний бус зориулалтаар ашиглах хэрэгсэл, хогийн сав зэрэг нь таглаатай, битүүмжлэлтэй, цэвэрлэж ариутгахад тохиромжтой материалаар хийгдсэн байх бөгөөд тусгайлсан таних тэмдэгтэй байна. Эдгээрийг өөр зориулалтаар ашиглаж болохгүй бөгөөд нэг удаагийн сав, уут хэрэглэх.

Тав.Үйлдвэр, цехийн хүний нөөцөд тавигдах шаардлага

5.1.Үйлдвэр, цех нь технологич, инженер, техникийн ажилтан, чанарын хяналтын ажилтан, технологийн дамжлагын ажилтантай байх бөгөөд 50 ба түүнээс олон ажилтантай бол орон тооны эрүүл ахуйчтай байна. Эдгээр ажилтан нь дараах шаардлагыг хангасан байна:

5.1.1.Технологич, инженер, техникийн ажилтан нь холбогдох чиглэлээр их, дээд сургууль, коллеж төгссөн, мэргэжлийн үнэмлэх, түүнийг нотлох баримт бичигтэй байх;



5.1.2.Технологийн дамжлагын ажилтан хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуй, технологийн чиглэлээр мэргэжлийн болон мэргэшүүлэх боловсрол олгох сургалтад хамрагдсан үнэмлэхтэй байх;

5.1.3.Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчээс зохион байгуулсан хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлын мэдлэг олгох болон энэ чиглэлийн хууль, эрх зүйн орчин, заавар, журам, стандартыг ашиглах, хэрэглэх сургалтад жилд 1-ээс доошгүй удаа хамрагдсан байх.

Зургаа.Үйлдвэр, цехийн түүхий эд, бүтээгдэхүүнд тавигдах шаардлага

6.1.Малын түүхий сүүний чанар, аюулгүй байдлын үзүүлэлт нь норматив эшлэлд заасан холбогдох стандартын шаардлагыг хангасан байх;

6.2.Хүүхдийн хоол тэжээлд зориулсан түүхий сүү нь $4 \pm 2^{\circ}\text{C}$ температурт 24 цагаас илүүгүй (тээврийн хугацаа ороод) хадгалсан, “MNS 4228, Малын түүхий сүү, Техникийн шаардлага” стандартад заасан дээд зэргийн сүүний шаардлага хангасан байх;

6.3.Хүүхдийн тэжээлийн сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд зориулсан үнээний түүхий сүүний соматик эсийн тоо 1 мл сүүнд 5×10^5 -аас ихгүй байх.

Долоо.Үйлдвэр, цехэд ашиглах цэвэр өсгөврийн хөрөнгөд тавигдах шаардлага

7.1.Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардлагатай дан буюу хосолмол үйлчлэлтэй цэвэр өсгөврийн хөрөнгийг “Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах журам”-д заасны дагуу бүртгүүлж, үйлдвэрлэлд хэрэглэх;

7.2.Цэвэр өсгөврийн хөрөнгө болон ашигтай бичил биетний өсгөвөрлөх тэжээлийн орчин, хөрөнгө, ферментийн бэлдмэлийн аюулгүй үзүүлэлт нь тухайн орны холбогдох стандартын шаардлага хангасан байх;

7.3.Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хэрэглэх бичил биетний өсгөвөр, хөрөнгө, ферментийн бэлдмэлүүд нь хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангахтай холбоотой олон улсын стандарт болон нийлүүлэгч улс, Монгол Улсын холбогдох стандарт, норматив баримт бичигт тогтоосон шаардлагад нийцсэн байх;

7.4.Гарал үүсэл нь тодорхойгүй, зохих журмын дагуу бүртгэгдээгүй, хэрэглэх болон хадгалах хугацаа хэтэрсэн, битүүмж алдагдсан хөрөнгө болон бичил биетний цэвэр өсгөвөр ашиглахгүй байх;

7.5.Хүүхдийн хоол тэжээлийн зориулалттай бүтээгдэхүүнд генийн өөрчлөлттэй амьд организмын оролцоотой гарган авсан хөрөнгө, эсхүл ферментийн бэлдмэлийг ашиглахгүй байх.

Найм.Сүү, сүүн бүтээгдэхүүнд тавигдах нийтлэг шаардлага

8.1.Нийтийн хэрэгцээнд худалдан борлуулах сүү, сүүн бүтээгдэхүүн, нялх, балчир хүүхдийн сүүн тэжээлд агуулагдах хүнд металл, микотоксин, антибиотیکیн үлдэгдэл, пестицид, цацрагийн үзүүлэлтүүд нь норматив эшлэлд заасан холбогдох стандартын шаардлагыг хангасан байх;

8.2.Нийтийн хэрэгцээнд худалдан борлуулах сүү, сүүн бүтээгдэхүүнд агуулагдах бичил биетний зөвшөөрөгдөх хэмжээ нь норматив эшлэлд заасан холбогдох стандартын шаардлагыг хангасан байх;

8.3.Сүү боловсруулах үйлдвэрлэлд хэрэглэх хүнсний нэмэлт нь “MNS SAC 192, Хүнсний нэмэлт” стандартын шаардлагыг хангасан, баяжуулах эрдэс бодис, аминдэм нь эрх бүхий байгууллагаас хүнсний бүтээгдэхүүнд хэрэглэхийг зөвшөөрсөн байх бөгөөд тэдгээрийн хэмжээ нь тогтоосон нормтой нийцсэн байх;

8.4.Баяжуулсан сүүн бүтээгдэхүүн дэх ашигтай бичил биетний тоо, аминдэм, эрдсийн хэмжээ нь холбогдох стандартын шаардлагыг хангасан байх;

8.5.Хүүхдийн тэжээлийн сүүн бүтээгдэхүүн дараах шаардлагыг хангасан байна:

8.5.1.илчлэг чанар нь хүүхдийн наснаас хамаарах бөгөөд хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, бие физиологийн нормд тохирсон байх;

8.5.2.стандарт, нормд заасан хүнсний бүтээгдэхүүний тэжээллэг чанар, аюулгүй байдлын шаардлагад нийцсэн байх;

8.5.3.нярай болон өсвөр насны хүүхдийн тэжээлийн сүүн бүтээгдэхүүнд агуулагдах хорт бодис болон исэлдэлтийн зөвшөөрөгдөх хэмжээ нь холбогдох шаардлагыг хангасан байх;



8.5.4.нярай болон өсвөр насны хүүхдийн тэжээлийн сүүн бүтээгдэхүүнд агуулагдах бичил биетний хэмжээ нь зохих стандартын шаардлагыг хангасан байх;

8.5.5.химийн гаралтай хүнсний будаг, үнэр, амт оруулагч, хувиргасан амьд организмыг ашиглан гаргаж авсан бүрдлийг агуулаагүй байх;

8.5.6.нярай болон өсвөр насны хүүхдийн тэжээлийн сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн аминдэм, эрдэс бодис, хүнсний нэмэлтүүдийг ашиглах бөгөөд тэдгээрийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь “MNS CAC 192, Хүнсний нэмэлт стандарт”-ын шаардлага болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн хэмжээнд байх;

8.5.7.сүүн бүтээгдэхүүний эрүүл ахуйн аюулгүй байдлын үзүүлэлтэд тавих шаардлагыг хүүхдийн (бага насны, сургуулийн өмнөх болон сургуулийн насны хүүхэд) эрүүл мэндэд учирч болзошгүй хохирлын эрсдэлийн ангиллын шалгуур үзүүлэлтээр тогтоосон байх;

8.5.8.сургуулийн болон сургуулийн өмнөх насны хүүхдийн тэжээлийн сүүн бүтээгдэхүүнд агуулагдах хорт бодисын хэмжээ нь “MNS CAC 193, Хүнсний бүтээгдэхүүн дэх хорт болон бохирдуулагч бодисын ерөнхий стандарт”-ын шаардлага хангасан байх;

8.5.9.этилийн спиртийн агууламж 0,2%-аас ихгүй байх;

8.5.10.цууны хүчил (уксус) агуулаагүй байх;

8.5.11.кофе агуулаагүй байх;

8.5.12.чангаанзны ясны үр агуулаагүй байх;

8.5.13.эмчилгээ, сувилгааны зориулалтаас бусад төрлийн амт оруулагч агуулаагүй байх;

8.5.14.нялх, балчир насны хүүхдэд зориулсан бүтээгдэхүүн нь транс тос агуулаагүй байх;

8.5.15.хадгалалтын хугацааг уртасгах зорилгоор бензойны, сорбины хүчил болон тэдгээрийн давсыг ашиглаагүй байх;

8.5.16.аарцанд агуулагдах хүчиллэгийн хэмжээ 150°Т (теннерийн градус)-аас ихгүй байх;

8.5.17.Пестицид агуулаагүй байх.

8.6.Ундны болон хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэгдэх сүүнд сүү орлуулагч, ургамлын гаралтай сүүн бүтээгдэхүүн ашиглахгүй байх.

Ес.Сүү боловсруулах технологи ажиллагаанд тавигдах шаардлага

9.1.Сүү, сүүн бүтээгдэхүүний нэр төрөл бүрийн жор, орц, технологийн зааврыг үйлдвэр, цехийн холбогдох албан тушаалтан баталж мөрдүүлэн, технологийн дамжлага, үе шат бүрд хяналтын бүртгэл хөтөлдөг байх;

9.2.Үйлдвэр, цехийн ажилтан нь чанарын хяналтын болон технологийн дараах бүртгэл, тэмдэглэлийг хөтөлдөг байна:

9.2.1.түүхий эд, материал, хүнсний нэмэлтийн ул мөрийг мөрдөн тогтоох;

9.2.2.үйлдвэрлэлийн буюу технологийн дамжлагын хяналт;

9.2.3.бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, түгээлт;

9.2.4.бэлэн бүтээгдэхүүний чанарын хяналт;

9.2.5.бүтээгдэхүүний буцаалт, устгал;

9.2.6.лабораторийн сорилтын дүнгийн мэдээллийн сан;

9.2.7.мэргэжлийн сургалт;

9.2.8.ажилтнуудын ариун цэвэр, эрүүл ахуй;

9.2.9.тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ;

9.2.10.угаалга цэвэрлэгээ, халдваргүйтгэл, шавж, мэрэгчээс урьдчилан сэргийлэх, устгах үйл ажиллагаа;

9.2.11.шинэ техник, технологийн туршилт хийсэн тухай.

9.3.Цэвэр өсгөврийн хөрөнгийг ариун цэврийн шаардлага хангасан орчинд бэлтгэдэг байх;



9.4.Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа 2 цагаас дээш хугацаатай тасалдсан тохиолдолд дулааны боловсруулалт хийсэн сүү, хольцод чанарын үзлэг хийж, давтан боловсруулах.

Арав.Сүү, сүүн бүтээгдэхүүний савлагаа, шошгололтод тавигдах шаардлага

10.1.Бэлэн бүтээгдэхүүнтэй хүрэлцэх сав, баглаа, боодлын материалыг шаардлагын дагуу хадгалж, үйлдвэрлэлд хэрэглэхийн өмнө гадна баглаа, боодлыг цэвэрлэсний дараа задлах;

10.2.Сүү, сүүн бүтээгдэхүүний шошго нь “MNS 6648, Хүнсний бүтээгдэхүүний сав, боодлын шошгололтод тавих шаардлага” стандартын шаардлагыг хангасан байх;

10.3.Сүү, сүүн бүтээгдэхүүнд хэрэглэх сав, баглаа, боодлын материал нь “MNS 5684, Сав, баглаа, боодлын материалд агуулагдах, хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандартын шаардлагыг хангасан байх;

10.4.Экспортын бүтээгдэхүүнийг импортлогч орны эрх бүхий байгууллагатай байгуулсан мал эмнэлэг, хорио цээрийн хэлэлцээр болон стандартад заасныг баримтлах;

10.5.Нялх, балчир болон хүүхдэд зориулсан сүүн тэжээл, сүүн бүтээгдэхүүний шошгын мэдээлэл нь Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн 7, 8 дугаар зүйлд заасныг хангасан байх;

10.6.Сүү, сүүн бүтээгдэхүүний шошгод гарал үүслийг малын төрлөөр заах;

10.7.Сүү, сүүн бүтээгдэхүүний шошгод хэрэглэгчдийг төөрөгдөлд оруулахуйц үг хэллэг хэрэглэхгүй байх;

10.8.Сүү, сүүн бүтээгдэхүүний сав, баглаа боодлыг нээж задалснаас хойших хадгалах нөхцөл болон хугацааг заах;

10.9.Бүтээгдэхүүний гадаргууд дардас дарах, наалт наах тохиолдолд хүнсний зориулалтын бэх, будаг, цавууг ашиглах.

Арван нэг.Бүтээгдэхүүнийг хадгалах, тээвэрлэхэд тавигдах шаардлага

11.1.Сүү, сүүн бүтээгдэхүүнийг хадгалах, тээвэрлэх нөхцөл нь норматив эшлэлд заасан холбогдох стандарт шаардлагыг хангасан байх;



11.2. Үйлдвэрлэл, боловсруулалт, түгээлтийн үе шат бүрд сүү, сүүн бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох тогтолцоог нэвтрүүлсэн байх;

11.3. Сүү, сүүн бүтээгдэхүүнийг зориулалтын, хөргүүртэй чингэлэг бүхий тээврийн хэрэгслээр тээвэрлэх ба чингэлгийн доторх гадаргуу нь гөлгөр, бат бөх, цэвэрлэж халдваргүйжүүлэхэд хялбар материалаар хийгдсэн, жижиг хортон, мэрэгч болон бохирдуулагч бусад зүйл нэвтрэхээс сэргийлсэн битүүмжлэлтэй байх.

Арван хоёр. Сүү, сүүн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэр, цехийн цэвэрлэгээ, халдваргүйтгэл, ариутгалд тавигдах шаардлага

12.1. Цэвэрлэгээ, халдваргүйтгэл нь “MNS CAC RCP 1, Хүнсний эрүүл ахуйн зарчим стандарт”-ын шаардлагыг хангасан байх;

12.2. Үйлдвэр нь сүү, сүүн бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангах, үйлдвэрийн байр, агуулах, тоног төхөөрөмж, шугам хоолой, багаж хэрэгсэл, сав, баглаа, тээврийн хэрэгслийн угаалга, ариутгал, халдваргүйтгэл хийх журмыг баталж мөрдөх;

12.3. Үйлдвэр, цехийн тоног төхөөрөмж, шугам хоолойг битүү системээр эргэлдүүлэн угаах болон (органик үлдэгдэл болон эрдэс бодисыг хүчил, шүлтээр угааж зайлах), механик арга (уураар, халуун усаар, халдваргүйжүүлэх бодисоор угааж, зайлах арга)-ын аль нэгээр, эсхүл хослуулан хэрэглэх;

12.4. Тоног төхөөрөмж болон салгаж угааж, цэвэрлэх шаардлагатай шугам хоолой, савны угаалга хийх зориулалттай шүршигч, холболт, шүүлтүүр зэрэг задалж ариутгах эд ангиуд, гадаргууд угаалга, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг хийдэг байх;

12.5. Ариутгал, халдваргүйтгэлд эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн зориулалтын химийн бодисыг хэрэглэх бөгөөд ашиглах заавар, зохистой тун хэмжээ, зориулалтын талаарх мэдээллийг агуулсан самбарыг шаардлагатай хэсэгт байршуулсан байх;

12.6. Химийн бодисыг хүнсийг бохирдуулах эрсдэлээс сэргийлж зориулалтын тусгай агуулах, хэсэгт хадгалж, хэрэглээний бүртгэл хөтөлдөг байх;

12.7. Халдваргүйжүүлэх химийн бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу найруулж хэрэглэх бөгөөд найруулсан уусмалд бэлтгэсэн огноо, концентрацийн хэмжээг тэмдэглэж, бүртгэл хөтөлөх;

12.8.Тоног төхөөрөмж, шугам хоолойн угаалга, халдваргүйжүүлэлт хийх хугацаа, угаалга, халдваргүйжүүлэлтийн бодисын концентраци, температурт тогтмол хяналт тавьж, бүртгэл хөтлөх;

12.9.Хөргөх, хөлдөөх, хадгалах зориулалт бүхий агуулахад хуурай цэвэрлэгээ хийж, хөлдөөгчийн цас, мөсийг хайлуулан цэвэрлэж, халдваргүйжүүлэх;

12.10.Сүү хадгалах, хөргөх зориулалтын цуглуулах саванд байгаа сүүг юүлж дууссанаас хойш 2 цагийн дотор, эсхүл угаалга, ариутгал хийгдсэний дараа 6-24 цагийн туршид ашиглаагүй тохиолдолд угаалга, ариутгалыг дахин хийж, бүрэн автомат тоног төхөөрөмжийн хувьд тоног төхөөрөмж үйлдвэрлэгчээс заасан шаардлагыг мөрдөж ажиллах;

12.11.Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд 2 цагаас дээш хугацаанд саатал гарсан тохиолдолд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна:

12.11.1.дулааны боловсруулалт хийсэн бүтээгдэхүүнийг асептик биш нөхцөлд хадгалсан тохиолдолд буцаан татаж, тоног төхөөрөмж, шугам хоолойд угаалга, халдваргүйтгэл хийх;

12.11.2.савлагааны тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчээс тогтоосон горим, хугацаанд тохируулан угаалга, ариутгалыг дахин хийх.

12.12.Тоног төхөөрөмж, шугам хоолой, сүү хөргөх танкын угаалга, халдваргүйжүүлэлтийн үр дүнг дотоод хяналтын хөтөлбөрт тусгаж, эмгэг төрөгч бичил биетний үлдэц байгаа эсэхэд улиралд 1-ээс доошгүй удаа лабораторийн шинжилгээ хийлгэж, бүртгэл хөтлөх;

12.13.Үйлдвэр болон агуулахын орчин, ажлын байр, тээврийн хэрэгслийг тогтмол цэвэрлэж, халдваргүйжүүлэх хөтөлбөртэй байх;

12.14.Үйлдвэрлэлийн дотоод орчныг эрүүл ахуйн шаардлагаар нь ангилж, бүсчилнэ. Эрүүл ахуйн эрсдэл дунд болон ихтэй хэсгийн агаар орчинд дараах аргуудыг дангаар болон хослуулсан байдлаар халдваргүйжүүлэлтийг хийнэ:

-Ультра гэрлээр;

-Озонжуулагч төхөөрөмжөөр;

-Халдваргүйжүүлэх бодисыг манантуулан цацах.



12.15.Үйлдвэрлэлийн орчны агаарын бохирдлыг үйлдвэрлэлийн хяналтын хөтөлбөрт тусгаж, үлдэц байгаа эсэхэд лабораторийн шинжилгээ хийдэг байх.

Арван гурав.Сүү, сүүн бүтээгдэхүүнийг худалдан борлуулахад тавигдах шаардлага

13.1.Энэхүү техникийн зохицуулалтын шаардлага хангасан сүү, сүүн бүтээгдэхүүнийг худалдаанд нийлүүлэх;

13.2.Сүү, сүүн бүтээгдэхүүний нэр төрөл бүрд тохирсон хадгалалтын горим, нөхцөл, шаардлагыг хангасан худалдааны үйл ажиллагааг албан ёсоор эрхлэх зөвшөөрөл, бүртгэлтэй худалдаа, үйлчилгээний газарт худалдаалах;

13.3.Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, сувиллын хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэхдээ лабораторийн сорилтын дүнг дагалдуулах;

13.4.Мал эмнэлгийн болон импортын гэрчилгээгүй, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 27.5-д заасны дагуу олгосон лабораторийн шинжилгээнд хамрагдаагүй сүү, цагаан идээ, сүүн бүтээгдэхүүнийг нийтийн хэрэгцээнд нийлүүлэхгүй байх;

13.5.Сүү, сүүн бүтээгдэхүүнийг худалдах, уг бүтээгдэхүүнээр үйлчлэх газар нь температурын тохируулга хийх боломжтой, гаднын бохирдлоос хамгаалсан шилэн хаалттай, зориулалтын хөргөлт бүхий тоног төхөөрөмжтэй байх ба тэдгээрийг ариун цэвэр, эрүүл ахуйн дүрмийн дагуу цэвэрлэж, халдваргүйтгэж, бүртгэл хөтлөх;

13.6.Зориулалтын савлагаагүй (ил задгай) сүү, сүүн бүтээгдэхүүнийг худалдаалахгүй байх;

13.7.Үйлдвэрлэл эрхлэгч нь зах зээлд бүтээгдэхүүн нийлүүлэхдээ түгээлтийн бүртгэл хөтлөлтийг цахимаар, эсхүл цаасан хэлбэрээр хөтөлж, архивлах;

13.8.Хүүхдэд зориулсан сүү, сүүн бүтээгдэхүүнийг хадгалах баталгаатай нөхцөлийг хангасан худалдааны байгууллага, борлуулах цэгээр дамжуулан худалдаалах;

13.9.Бүтээгдэхүүний хадгалалтын хүчинтэй хугацааг засварлах, өөрчлөх, эсхүл хүчинтэй хугацаа хэтэрсэн сүү, сүүн бүтээгдэхүүн худалдаалахыг хязгаарлах;

13.10.Худалдаа үйлчилгээ эрхлэгч нь Хүнсний тухай хуулийн 12.1-д заасны дагуу өөрт хамаарах үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангаж, хадгалах болон хэрэглэх хугацаа дууссан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч, нийлүүлэгчид буцаахгүй байх;

13.11.Сүү, сүүн бүтээгдэхүүнийг хүнсний бус зориулалтын нийлэг хальсан уут, хуванцар сав, баглаа боодолд савлаж худалдаалахгүй байх.

Арван дөрөв.Бүтээгдэхүүнийг буцаан болон татан авах, устгах, дахин боловсруулахад тавигдах шаардлага

14.1.Хүнсний чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй сүү, сүүн бүтээгдэхүүнийг хүнсний сүлжээнээс татан авах, устгах, дахин боловсруулах үйл ажиллагааг Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 8.10-д заасан журмын дагуу зохион байгуулах;

14.2.Худалдаа, үйлчилгээний үед гарсан бүтээгдэхүүний гологдлыг зах зээлээс татан авах талаар үйлдвэрлэгч болон худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн хооронд хийсэн гэрээнд тусгасан байх;

14.3.Худалдааны төв, зах, дэлгүүр, агуулах, бөөний төв, харилцагчийн агуулах зэрэг цэгээс стандартын шаардлага хангаагүй, үл тохирох бүтээгдэхүүнийг эргүүлэн татах, устгах журмыг боловсруулан, мөрдөж ажиллах;

14.4.Хүнсний худалдаа, үйлчилгээ эрхлэгч нь хадгалалт, худалдаалах явцад өөрийн буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй сүү, сүүн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал алдагдсанаас учирч болох эрсдэлийг бүрэн хариуцах;

14.5.Худалдаа үйлчилгээ эрхлэгч нь хадгалах болон хэрэглэх хугацаа дууссан бүтээгдэхүүнийг устгаж, баримтжуулж акт үйлддэг байх;

14.6.Хадгалалтын хугацаа дууссан, лабораторийн шинжилгээгээр стандартын шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг хяналт шалгалтаар илрүүлсэн тохиолдолд эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хурааж, түргэн гэмтэх бүтээгдэхүүнийг холбогдох хууль, журмын дагуу устгах, бусад түүхий эд, бүтээгдэхүүнийг аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураан авсан хөрөнгө, эд зүйл, хэрэгслийг үнэлэх, худалдан борлуулах, устгах талаар шийдвэр гаргах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий зөвлөлд шилжүүлж шийдвэрлүүлэх;

14.7.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэж үзвэл



тэдгээрийг хүнсний сүлжээнээс татан авч хүнсний хэрэглээнд нийлүүлэх боломжгүйг тогтоосон тохиолдолд хөндлөнгийн хяналтыг байлцуулан устгал хийж, акт үйлдэн тухайн мэдээллийг өөрийн архивд баримтжуулж хадгалах;

14.8.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр түүхий эд, сүү, сүүн бүтээгдэхүүнийг хүнсний сүлжээнээс татан авсан, устгал хийсэн тохиолдолд тухай бүр устгалын акт үйлдэж, хяналтын байгууллагад албан ёсоор мэдээлэх;

14.9.Хадгалалтын хугацаа дууссан сүү, сүүн бүтээгдэхүүнийг нийтийн хэрэгцээнд нийлүүлэхгүй байх;

14.10.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг дахин боловсруулах тохиолдолд дотоод хяналт болон итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний хариуг үндэслэн гүйцэтгэх бөгөөд дахин боловсруулалт хийсэн бүтээгдэхүүнийг хөндлөнгийн, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулан энэ талаар хяналтын байгууллагад мэдээлэх.

Арван тав.Сүү, сүүн бүтээгдэхүүнийг импортлоход тавигдах шаардлага

15.1.Дэлхийн худалдааны байгууллагын “Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн хэлэлцээр (SPS Agreement)”-ийг мөрдөх;

15.2.Мал, амьтнаас хүнд дамжин халдварладаг зооноз өвчин, олон улсын худалдааны хориг бүхий халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын “Газрын амьтны эрүүл мэндийн кодекс”, гадаад улсын эрх бүхий байгууллагатай байгуулсан мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах ерөнхий хэлэлцээр, мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн хэлэлцээрт заасан нөхцөлийг баримтлах;

15.3.Монгол Улсад сүү, сүүн бүтээгдэхүүн экспортлогч улсын үйлдвэр нь “MNS CAC RCP 57, Сүү, сүүн бүтээгдэхүүний эрүүл ахуйн дадлын дүрэм”, “MNS ISO 22000, Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд эрхлэгчид тавих шаардлага” стандарт болон энэ техникийн зохицуулалтын шаардлагыг хангасан байх;

15.4.Хэд хэдэн улсыг хамарсан цар тахлын дэгдэлтийн үед сүү, сүүн бүтээгдэхүүн импортлоход хүн, мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг өөрийн улсын хууль тогтоомж болон Дэлхийн эрүүл мэндийн



байгууллага, Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийг баримтлан хэрэгжүүлэх;

15.5.Импортын сүү, сүүн бүтээгдэхүүн нь энэ техникийн зохицуулалтад заасан бүтээгдэхүүний нэршил, хаяг шошготой, аюулгүй үзүүлэлтийн шаардлага хангасан, “MNS 6648, Хүнсний бүтээгдэхүүний сав, боодлын шошгололтод тавих шаардлага” стандартыг хангасан байх;

15.6.Импортлогч нь сүү, сүүн бүтээгдэхүүнийг хадгалах нөхцөл, горимын шаардлага хангасан хөргүүр бүхий агуулахад хадгалж, тээвэрлэх.

---o0o---

хүснэгт 1. Үйлдвэр, ажлаас үндэслэн
2025 он №38/1383/

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖИЛТ
МОНГОЛ УЛСЫН ХӨГЖИЛТ

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖИЛТ

1. Үйлдвэр, ажлаас үндэслэн

2025 он №38/1383/

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖИЛТ

Հովանավորում... համընթացական. ԶԿԻԼԻ ԱճԻ ԴԱՐ ԴՏԱԿԱՆ ԴՏԱԿԱՆ ՏՈՒՆՏԱԿԱՆ
ՏՈՒՆՏԱԿԱՆ ԴՏԱԿԱՆ ԴՏԱԿԱՆ ՏՈՒՆՏԱԿԱՆ ԴՏԱԿԱՆ ՏՈՒՆՏԱԿԱՆ

6.0.6. Մտնելով հիմնականում առարկայի և համընթացական կապի կենտրոնում, հարկային հարկերի արդյունավետության բարելավումը, հետևյալի տեսլականը կարևորագույնը է, որը կարող է կիրառվել միայնակ կամ իրավաբանական կազմակերպությունների կողմից: Միջազգային փոխանակման հարկային կառավարման և կառավարման արդյունավետության բարելավումը, հետևյալի տեսլականը կարևորագույնը է, որը կարող է կիրառվել միայնակ կամ իրավաբանական կազմակերպությունների կողմից:

7. Համընթացական կառավարման մեթոդները և առարկայի կառավարման համընթացականության զարգացումը:

7.0.6. Մտնելով հիմնականում առարկայի և համընթացական կառավարման կենտրոնում, հարկային հարկերի արդյունավետության բարելավումը, հետևյալի տեսլականը կարևորագույնը է, որը կարող է կիրառվել միայնակ կամ իրավաբանական կազմակերպությունների կողմից:

8. Համընթացական կառավարման մեթոդները և առարկայի կառավարման համընթացականության զարգացումը:

8.0.6. Մտնելով հիմնականում առարկայի և համընթացական կառավարման կենտրոնում, հարկային հարկերի արդյունավետության բարելավումը, հետևյալի տեսլականը կարևորագույնը է, որը կարող է կիրառվել միայնակ կամ իրավաբանական կազմակերպությունների կողմից:

9. Համընթացական կառավարման մեթոդները և առարկայի կառավարման համընթացականության զարգացումը:
Համընթացական կառավարման մեթոդները և առարկայի կառավարման համընթացականության զարգացումը: Միջազգային փոխանակման հարկային կառավարման և կառավարման արդյունավետության բարելավումը, հետևյալի տեսլականը կարևորագույնը է, որը կարող է կիրառվել միայնակ կամ իրավաբանական կազմակերպությունների կողմից: Համընթացական կառավարման մեթոդները և առարկայի կառավարման համընթացականության զարգացումը:

10. Համընթացական կառավարման մեթոդները և առարկայի կառավարման համընթացականության զարգացումը:

10.0.6. Մտնելով հիմնականում առարկայի և համընթացական կառավարման կենտրոնում, հարկային հարկերի արդյունավետության բարելավումը, հետևյալի տեսլականը կարևորագույնը է, որը կարող է կիրառվել միայնակ կամ իրավաբանական կազմակերպությունների կողմից:

11. Համընթացական կառավարման մեթոդները և առարկայի կառավարման համընթացականության զարգացումը:
Համընթացական կառավարման մեթոդները և առարկայի կառավարման համընթացականության զարգացումը: Միջազգային փոխանակման հարկային կառավարման և կառավարման արդյունավետության բարելավումը, հետևյալի տեսլականը կարևորագույնը է, որը կարող է կիրառվել միայնակ կամ իրավաբանական կազմակերպությունների կողմից:

МОНГОЛЫН АЖ АХуйн ЯАМ. 2025.06.06. 2025 он №38/1383/

2025.06.06. 2025 он №38/1383/

2025.06.06. 2025 он №38/1383/



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 02 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 72

Улаанбаатар
хот

Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангийн хөрөнгийн удирдлагын бодлого батлах тухай

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 7.1.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Ирээдүйн өв сангийн хөрөнгийн удирдлагын бодлого”-ыг 1 дүгээр хавсралт, “Хуримтлалын сангийн хөрөнгийн удирдлагын бодлого”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангийн хөрөнгийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан нарт даалгаж, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнд зөвлөсүгэй.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаярт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

Засгийн газрын 2025 оны 02 дугаар
сарын 05-ны өдрийн 72 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН ХӨРӨНГИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО

Нэг.Ерөнхий зүйл

1.1.Энэ хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг (цаашид “Хөрөнгийн удирдлагын бодлого” гэх)-т Ирээдүйн өв сан (цаашид “Сан” гэх)-ийн хөрөнгийг удирдахад баримтлах зарчим, тавигдах шаардлага, хязгаарлалтыг тодорхойлж, хөрөнгө оруулалтын хэрэгслийн өгөөжийн доод хэмжээ, хөрөнгө оруулалтын жишиг багц, Сангийн хөрөнгөөс хөрөнгө оруулахыг хориглох санхүүгийн хэрэгсэл зэргийг тусгана.

1.2.Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлнэ.

1.3.Хөрөнгийн удирдлагын бодлогод хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1.“Идэвхтэй удирдлага” гэж нэмэлт өгөөж олох зорилгоор багцыг жишиг багцаас бүтэц болон эрсдэлийн үзүүлэлтийн хувьд мэдэгдэхүйц ялгаатайгаар удирдахыг;

1.3.2.“Хагас идэвхтэй удирдлага” гэж зөвшөөрөгдсөн эрсдэлийн хязгаарын хүрээнд жишиг багцын эрсдэлийн үзүүлэлтээс илүү эрсдэл хүлээх замаар багцын үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилт бүхий багцын удирдлагыг;

1.3.3.“Идэвхгүй удирдлага” гэж багцыг жишиг багц дахь хөрөнгө оруулалтын хэрэгслээр бүрдүүлж, өгөөж, эрсдэлийн ижил түвшинд удирдахыг;

1.3.4.“Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн зээлжих зэрэглэл тогтоогч байгууллага” гэж Эс энд Пи Глобал Рейтингс (Стандарт энд Пүүрс), Мүүдиз Рейтингс, эсхүл Фитч Рейтинг Инкийг;

1.3.5.“Хөрвөх чадварын эрсдэл” гэж хөрөнгө оруулалтыг тухайн зах зээлд түргэн борлуулах боломжгүйн улмаас хүлээж болзошгүй алдагдлыг;

1.3.6. “Зах зээлийн эрсдэл” гэж хүү болон валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан хөрөнгө оруулалтын үнэлгээ буурах эрсдэлийг;

1.3.7. “Зээлийн эрсдэл” гэж харилцагч байгууллагын санхүүгийн чадавх алдагдах, эсхүл буурснаас шалтгаалан хөрөнгө оруулалтыг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нь алдах, хөрөнгө оруулалтын үнэлгээ буурах эрсдэлийг;

1.3.8. “Төлбөр тооцооны эрсдэл” гэж гэрээнд заасан хугацаанд гэрээнд оролцогч тал төлбөр хийгээгүйгээс шалтгаалан үүсэж болох эрсдэлийг;

1.3.9. “Хамгийн их эрсдэл” гэж тодорхой хугацаанд, тодорхой магадлалтайгаар хүлээж болзошгүй алдагдлын дээд хэмжээг;

1.3.10. “Жишиг үзүүлэлтээс хазайх хэмжээ” гэж тухайн багцын өгөөж болон жишиг багцын өгөөжийн зөрүүний стандарт хазайлтыг;

1.3.11. “Үргэлжлэх хугацаа” гэж хүүгийн түвшний өөрчлөлтөөс хамааран тухайн санхүүгийн хэрэгслийн үнэ цэн хэрхэн (хувиар, эсхүл нэрлэсэн дүнгээр) өөрчлөгдөхийг харуулсан хүүгийн эрсдэлийн хэмжүүрийг.

1.4. Сангийн хөрөнгийг мөнгөний бодлого, макро эдийн засгийн орчны нөхцөлтэй уялдуулан удирдах бөгөөд энэхүү Хөрөнгийн удирдлагын бодлогыг 2030 он хүртэл баримтална.

Хоёр. Хөрөнгийн удирдлагын зорилго, зарчим

2.1. Сангийн хөрөнгийн удирдлагын зорилго нь Санд газрын хэвлийн баялгийн үр өгөөжөөс хуримтлагдсан хөрөнгийг олон улсын зах зээлийн санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах замаар урт хугацаанд өнөөгийн үнэ цэнийг өсгөх, арвижуулахад оршино.

2.2. Сангийн хөрөнгийг найдвартай, хөрвөх чадвартай байх нөхцөлийг зэрэг хангасны үндсэн дээр эрсдэл-өгөөжийн зохистой түвшнийг баримтлан удирдах бөгөөд Сангийн хөрөнгийн бүтцийг хөрөнгийн удирдлагын үндсэн зорилгод нийцүүлэн үе шаттайгаар төрөлжүүлнэ.

2.3. Сангийн хөрөнгийг удирдахад Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйл, Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмыг тус тус баримтална.

Гурав.Хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч

3.1.Сангийн хөрөнгийг Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5¹ дүгээр зүйлд заасны дагуу 2030 он хүртэл хугацаанд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага удирдах бөгөөд шаардлагатай тохиолдолд Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн хувиар гэрээ байгуулсны үндсэн дээр Монголбанкаар дамжуулан хэрэгжүүлж болно.

3.2.Хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь хөрөнгө оруулалтын шийдвэрийг Хөрөнгийн удирдлагын бодлого болон хууль тогтоомжид нийцүүлэн бие даан гаргана.

3.3.Хөрөнгийн удирдлагыг энэ бодлогод заасан ерөнхий бүтэц, бенчмаркийн дагуу идэвхтэй, хагас идэвхтэй, эсхүл идэвхгүй хэлбэрээр хэрэгжүүлж болно.

3.4.Хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор Сангийн хөрөнгийн удирдлагыг олон улсын санхүүгийн байгууллага, эсхүл хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлдэг, гадаадын мэргэшсэн хуулийн этгээдээр энэхүү бодлогын хүрээнд гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

3.5.Энэ бодлогын 3.4-т заасны дагуу удирдуулах хөрөнгийн эхний хэмжээ нь 200 сая ам.доллароос хэтрэхгүй байх бөгөөд уг хэмжээ нь хүүгийн орлого болон үнэлгээний зөрүүгээр нэмэгдэж болно.

3.6.Хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхэд үнэт цаас, хувьцааны төлбөр тооцоог гүйцэтгэх, хадгалах үйлчилгээг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

3.7.Энэ бодлогын 3.4, 3.6-д заасан байгууллагыг сонгоход үйлчилгээний шимтгэлийн хэмжээ, ижил төрлийн сангийн хөрөнгийг удирдаж байсан туршлагыг харгалзан үзэх бөгөөд гадаад валютын улсын нөөцийн удирдлагын үйл ажиллагаанд Монголбанктай хамтран ажилладаг байгууллагыг сонгож болно.

Дөрөв.Хөрөнгө оруулалтын өгөөжийн доод хэмжээ, хөрөнгө оруулах хэрэгсэл, жишиг багц

4.1.Сангийн хөрөнгө оруулалтын өгөөж нь багц тус бүрийн бенчмарк индексийн өгөөжийг тухайн багцын хөрөнгө оруулалтын бодит гүйцэтгэлийн хувиар жигнэсэн дундаж өгөөжөөс багагүй байна.

4.2. Сангийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг ам.доллаароор тооцож, тайлагнана.

4.3. Сангийн хөрөнгийг олон улсын санхүүгийн зах зээлд гаргасан гадаад улсын нутаг дэвсгэрт нээлттэй арилжаалагдаж байгаа, хөрөнгийн бирж буюу санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий этгээдэд бүртгүүлсэн дараах хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулна:

4.3.1. AA буюу түүнээс дээш зээлжих зэрэглэлтэй гадаад улсын Засгийн газрын үнэт цаас;

4.3.2. AA буюу түүнээс дээш зэрэглэлтэй олон улсын санхүүгийн байгууллагын үнэт цаас;

4.3.3. AA буюу түүнээс дээш зэрэглэлтэй Засгийн газрын баталгаатай болон дэмжлэгтэй байгууллагын үнэт цаас;

4.3.4. энэ бодлогын 4.4-т заасан бенчмарк индексийг дагадаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх;

4.3.5. Америкийн Нэгдсэн Улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй 500 том компанийн хувьцаа, хувьцааны индекс;

4.3.6. бэлэн валют, түүнтэй адилтгах хэрэгсэл;

4.3.7. Төвбанкны хадгаламж.

4.4. Сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулахад доор дурдсан хувь хэмжээний хязгаар, бенчмаркийг баримтална:

№	Багцын төрөл	Хөрөнгө оруулах хэрэгсэл	Нийт багцад эзлэх хувь	Бенчмарк
1	Тогтмол орлого-той үнэт цаасны багц	Энэ бодлогын 4.3.1-4.3.4-т заасан хэрэгсэл	0-100%	Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрын 0-5 жилийн хугацаатай үнэт цаасны индекс
2	Хувьцааны багц	Энэ бодлогын 4.3.5-д заасан хэрэгсэл	0-15%	Америкийн Нэгдсэн Улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй 500 том компанийн индекс

3	Түргэн хөрвөх хөрөнгийн багц	Энэ бодлогын 4.3.6-д заасан хэрэгсэл	0-5%	-
4	Төвбанкны хадгаламж	Энэ бодлогын 4.3.7-д заасан хэрэгсэл	0-100%	Монголбанкны харилцагч гадаад улсуудын Төвбанкны хадгаламжийн дундаж хүү

4.5. Сангийн хөрөнгө оруулалтын багцыг дараах тохиолдолд дахин тэнцвэржүүлнэ:

4.5.1. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд заасан эх үүсвэрээс Санд эх үүсвэр нэмж хуваарилагдсан;

4.5.2. энэ бодлогын 4.4-т заасан тухайн хөрөнгө оруулах хэрэгслийн нийт багцад эзлэх хувь 3 нэгж хувиас илүү хувиар хэлбэлзсэн;

4.5.3. хөрөнгө оруулалтын эрсдэлийн хязгаараас давсан.

4.6. Энэ бодлогын 4.3.1, 4.3.2, 4.3.3-т заасан хөрөнгө оруулалтын хэрэгсэл нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн зэрэглэл тогтоогч хоёроос доошгүй байгууллагаар зэрэглэл тогтоолгосон байна. Холбогдох зэрэглэлийн үнэлгээ нь зөрүүтэй тохиолдолд сүүлийн нэг жилд тогтоолгосон хоёр зэрэглэлийн үнэлгээний аль багаар нь, хэрэв сүүлийн нэг жилд тогтоолгосон хоёр зэрэглэлийн үнэлгээ байхгүй тохиолдолд хамгийн сүүлд тогтоолгосон зэрэглэлийн үнэлгээгээр тооцно.

4.7. Сангийн хөрөнгийн үнэлгээг санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн гаргана.

Тав. Хөрөнгө оруулалтад тавигдах шаардлага, хязгаарлалт

5.1. Сангийн хөрөнгийг ам.доллар болон бенчмарк индекс дэх хэрэгслийн нэрлэсэн бусад валютаар санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулна.

5.2. Сангийн хөрөнгийн удирдлагыг идэвхгүй хэлбэрээр хэрэгжүүлэх бол энэ бодлогын 4.4-т заасан бенчмарк индексэд багтсан хэрэгслүүдэд, идэвхтэй, эсхүл хагас идэвхтэй хэлбэрээр удирдах бол бодлогын 4.3-т заасан санхүүгийн хэрэгсэлд байршуулж удирдана.

5.3. Сангийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаанд дараах зүйлсийг хориглоно:



5.3.1.Сангийн хөрөнгийг дотоодын арилжааны банк, санхүүгийн байгууллагуудад хадгаламж хэлбэрээр байршуулах, тэдгээрийн гаргасан үнэт цаасанд хөрөнгө оруулах;

5.3.2.эрх бүхий этгээдэд бүртгүүлээгүй үнэт цаасанд байршуулах;

5.3.3.цэрэг, зэвсэг, хар тамхи, мансууруулах бодис, тамхи, согтууруулах ундааны үйлдвэрлэл, тэдгээрийн худалдаа, хуулиар хориглосон бусад үйл ажиллагаанд хөрөнгө оруулах;

5.3.4.авто зам, төмөр зам, нисэх буудал болон Хот байгуулалтын тухай хуулийн 3.1.10-д заасан инженерийн дэд бүтцэд хамаарах үл хөдлөх эд хөрөнгөд хөрөнгө оруулах;

5.3.5.Сангийн хөрөнгийг уул уурхай, эрдэс баялгийн салбарын компанийн хувьцаанд хөрөнгө оруулах;

5.3.6.Сангийн хөрөнгийг барьцаалах, зээл олгох, зээлийн баталгаа, батлан даалт гаргах болон бусдын үүргийн гүйцэтгэлийг аливаа хэлбэрээр хангах гэрээ, хэлцэл байгуулах;

5.3.7.санхүүгийн хэрэгсэлд байршуулсан хөрөнгийн хувь, хэмжээг хөрөнгө оруулж байгаа этгээдийн хяналтын багцын хувь, хэмжээнд хүргэх;

5.3.8.санхүүгийн хөшүүрэг, үнэт цаас зээлж худалдах аливаа төрлийн гэрээ, хэлцэл хийх;

5.3.9.санхүүгийн үүсмэл хэрэгслийг хөрөнгө оруулалтын зах зээлийн эрсдэлийг хаах, бууруулахаас бусад зорилгоор ашиглах.

Зургаа.Эрсдэлийн удирдлага

6.1.Хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь Сангийн эрсдэлийн удирдлагыг хүлээж болох эрсдэл, үр өгөөжийн зохистой харьцааг хангах замаар хэрэгжүүлнэ.

6.2.Хөрөнгийн удирдлагын хүрээнд гарч болох дараах эрсдэлийг удирдан зохицуулна:

6.2.1.Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага:

6.2.1.а.Сангийн хөрөнгийн тодорхой хэсгийг түргэн хугацаанд бэлэн валютад хувирах, хөрвөх чадвар өндөртэй хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах;

6.2.1.б.эрсдэл-өгөөжийн хэмжээг харгалзан нэг төрлийн хөрөнгө оруулалтын хэрэгсэлд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг хязгаарлах, тухайн нэг хөрөнгө оруулалт нь эзэмшиж байгаа нийт хэмжээгээрээ зах зээлд нэг удаа аливаа нэмэлт зардалгүйгээр борлуулагддаг байх шаардлагыг хангасан байх.

6.2.2.Зах зээлийн эрсдэлийн удирдлага:

6.2.2.а.их хэмжээний зах зээлийн эрсдэл хүлээхээс зайлсхийх;

6.2.2.б.хөрөнгө оруулалтын хугацаа нь 5 жил хүртэл байх.

6.2.3.Зээлийн эрсдэл, төлбөр тооцооны эрсдэлийн удирдлага:

6.2.3.а.хөрөнгө оруулалтын хэрэгсэл нь санхүүгийн хөшүүрэггүй байх;

6.2.3.б.зээлийн эрсдэлээс хамгаалах хэрэгсэл (баталгаа), бүртгэл, төлбөр тооцооны гэрээ, хэлцлийг ашиглах.

6.3.Сангийн хөрөнгө оруулалтын эрсдэлийг хөрөнгө оруулах хэрэгслийн төрөл тус бүрээр болон нийт багцын хувьд тооцно.

6.4.Хөрөнгө оруулалтын эрсдэлийг тооцоход дараах аргачлалыг ашиглана:

6.4.1.хамгийн их эрсдэлийг Сангийн хөрөнгө оруулалтын багцаас тодорхой хугацаанд тодорхой хувийн магадлалтайгаар хүлээж болзошгүй алдагдлын дээд хэмжээгээр тооцно;

6.4.2.жишиг үзүүлэлтээс хазайх хэмжээг Сангийн хөрөнгө оруулалтын багцын бодит өгөөжийг бенчмарктай харьцуулах замаар тооцно;

6.4.3.үнэт цаасны багцын хувьд үргэлжлэх хугацааг хүүгийн түвшний өөрчлөлтөөс хамааран тухайн санхүүгийн хэрэгслийн үнэ цэн хэрхэн (хувиар, эсхүл нэрлэсэн дүнгээр) өөрчлөгдөхөөр тооцно.



Долоо.Бусад

7.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Хөрөнгийн удирдлагын бодлогын хэрэгжилтийг жил бүр Засгийн газарт тайлагнана.

7.2.Хөрөнгийн удирдлагын бодлогод оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.

7.3.Хөрөнгийн удирдлагын бодлогын хэрэгжилтийг Сангийн үйл ажиллагааны тайланд тусгана.

7.4.Сангийн хөрөнгийн удирдлагыг Монголбанкаар дамжуулан гүйцэтгүүлэх тохиолдолд байгуулсан гэрээ болон Хөрөнгийн удирдлагын бодлогын хэрэгжилтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтмол хянаж, Засгийн газарт тайлагнана.

7.5.Сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн удирдлагатай холбоотой мэдээлэл ил тод байх бөгөөд мэдээллийг хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч байгууллага боловсруулан хуульд заасны дагуу тайлагнана.

----o0o----

Засгийн газрын 2025 оны 02 дугаар
сарын 05-ны өдрийн 72 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

ХУРИМТЛАЛЫН САНГИЙН ХӨРӨНГИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО

Нэг.Ерөнхий зүйл

1.1.Энэ хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг (цаашид “Хөрөнгийн удирдлагын бодлого” гэх)-т Хуримтлалын сан (цаашид “Сан” гэх)-ийн хөрөнгийг удирдахад баримтлах зарчим, тавигдах шаардлага, хязгаарлалтыг тодорхойлж, хөрөнгө оруулалтын хэрэгслийн өгөөжийн доод хэмжээ болон эрсдэлийн удирдлагын асуудлыг тусгана.

1.2.Үндэсний баялгийн сангийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцүүлэн Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлнэ.

Хоёр.Хөрөнгийн удирдлагын зорилго, зарчим

2.1.Сангийн хөрөнгийн удирдлагын зорилго нь Санд газрын хэвлийн баялгийн үр өгөөжөөс хуримтлагдсан хөрөнгийг хөрөнгө оруулалт хийх замаар үнэ цэнийг хадгалах, арвижуулахад оршино.

2.2.Сангийн хөрөнгийг удирдахад Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмыг баримтална.

Гурав.Хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч

3.1.Сангийн хөрөнгийн удирдлагыг Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10.3-т заасны дагуу Монголбанк Засгийн газартай гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ.

3.2.Энэ бодлогын 3.1-д заасан гэрээг Засгийн газрыг төлөөлж Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 8.2.1-д заасан Сангийн үйл ажиллагааны удирдлага буюу хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газарт танилцуулсны үндсэн дээр байгуулна.

Дөрөв.Хөрөнгө оруулалтын өгөөжийн доод хэмжээ, хөрөнгө оруулах хэрэгсэл

4.1.Сангийн хөрөнгө оруулалт нь Үндэсний баялгийн сангийн тухай хуульд зааснаас багагүй өгөөжтэй байна.



4.2. Монголбанк энэ бодлогын 3.1-д заасан гэрээний дагуу Сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд Үндэсний баялгийн сангийн тухай хуульд заасны дагуу хүү тооцох, эсхүл дараах хөрөнгө оруулах хэрэгсэлд хөрөнгө оруулна:

4.2.1. Монгол Улсын Засгийн газрын үнэт цаас;

4.2.2. төрийн өмчит компанийн хувьцаанаас бусад үнэт цаас, санхүүгийн хэрэгсэл;

4.2.3. төрөөс хэрэгжүүлж байгаа орон сууцны санхүүжилтийн хөтөлбөр.

Тав. Хөрөнгө оруулалтад тавигдах шаардлага, хязгаарлалт

5.1. Хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь Сангийн эрсдэлийн удирдлагыг хүлээж болох эрсдэл, үр өгөөжийн зохистой харьцааг хангах замаар хэрэгжүүлнэ.

5.2. Сангаас хийх хөрөнгө оруулалт нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан иргэний эрүүл мэнд, боловсрол, орон сууцны талаарх зорилт, арга хэмжээтэй нийцсэн байна.

5.3. Сангийн хөрөнгийг арилжааны банканд аливаа хэлбэрээр байршуулахыг хориглоно.

5.4. Засгийн газар энэ журмын 5.2-т заасны дагуу Сангаас хөрөнгө оруулалт хийх зорилт, арга хэмжээг Сангийн хөрөнгийн хэмжээ, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмж, хэрэгцээ шаардлагаас хамаарч эрэмбэлж болно.

Зургаа. Бусад

6.1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Хөрөнгийн удирдлагын бодлогын хэрэгжилтийг Засгийн газарт жил бүр тайлагнана.

6.2. Хөрөнгийн удирдлагын бодлогод оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.



6.3.Хөрөнгийн удирдлагын бодлогын хэрэгжилтийг Сангийн үйл ажиллагааны тайланд тусгана.

6.4.Сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн удирдлагатай холбоотой мэдээлэл ил тод байх бөгөөд уг мэдээллийг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгтгэн хуульд заасны дагуу тайлагнана.

---o0o---

Бусад үндэсний хэргийн тухай хууль

МОНГОЛЫН ХУУЛЬ

Хууль

2007 оны 11 сарын 26 - өдөр / 11 сарын 26 /

МОНГОЛЫН ХУУЛЬ
Хууль
Хууль

МОНГОЛЫН ХУУЛЬ / 2007 оны 11 сарын 26 - өдөр /
Хууль

МОНГОЛЫН ХУУЛЬ / 2007 оны 11 сарын 26 - өдөр /
Хууль

МОНГОЛЫН ХУУЛЬ / 2007 оны 11 сарын 26 - өдөр /
Хууль

МОНГОЛЫН ХУУЛЬ / 2007 оны 11 сарын 26 - өдөр /
Хууль

МОНГОЛЫН ХУУЛЬ

Хууль

Хууль

МОНГОЛЫН ХУУЛЬ

